

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021оны 11 дүгээр сарын 09-ний өдөр
Тендерийн дугаар: МРЦМ/202112198

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх, нөөц тогтоогдсон хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрөл авах (3 багц) зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг үнийн санал ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших XV-020521 (багц 1), XV-020580 (багц 2) тоот алтын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад геологи хайгуулын ажил гүйцэтгэх, ГХА-ын ажлын үр дүнгээр нөөцийн тайлан боловсруулж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хамгаалах, нөөц тогтоогдсон хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрөл авах зөвлөх үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэснээр ТӨҮГ-ын харъяа “Шижир алт” АҮ-ийн алтын нөөцийг нэмэгдүүлж үйлдвэрийн бүтээмжийг өсгөх болно.
3. Үнийн санал ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
 - Зөвлөх хуулийн этгээдийн санхүүгийн чадавхийн мэдээлэл /сүүлийн 1 жилийн буюу 2020 оны санхүүгийн тайлан ирүүлэх/,
 - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ ирүүлнэ.
 - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
 - Сүүлийн 1 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт эсхүл гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт.
4. Үнийн санал авах сонгон шалгаруулалтын баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **50000** төгрөгөөр худалдан авна.
5. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2021 оны 11 дүгээр сарын 11–ний өдрийн 10 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 10 цагаас өмнө доорхи хаягаар ирүүлнэ.
6. Тендерийг 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 10.10 цагт нээнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х – 002

Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө.

22-р хороо, “Монголросцветмет” ТӨҮГ-ын байр, 504 тоот,

И-мейл: mailbox@monros.mn.

Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-458675, 976-11-450060-158